



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА О.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 02/38 ЧАТ-ГАТ/2013/02-0113-0114

Зөрчил арилгах тухай

Гаалийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар ГЕГ-ын системийн хэмжээнд 2012 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 9 гаалийн улсын байцаагч нарт цолны нэмэгдлийг 36 сараар тооцон 31.1 сая төгрөг олгосон зөрчил илэрсэн нь Төрийн албаны тухай хуулийн 30.2, Засгийн газрын 2009 оны 164 дүгээр тогтоолын 3 дах заалтыг, ГЕГ-ын даргын 2012 оны Б/558 дугаар тушаалаар Сангийн яамны нэр бүхий 3 төрийн албан хаагчид нийтдээ 66.0 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлт олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх алдаа, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч А.Болор-эрдэнэ нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 25 -ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ч.БОЛД

070134